



МОНГОЛ УЛСЫН  
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,  
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД

13381 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,  
Энхтайвны өргөн чөлөө 16а, Засгийн газрын IX байр,  
Утас 26 22 71, Факс: (976-51) 26 32 37,  
E-mail: mofa@mofa.gov.mn, http://www.mofa.gov.mn

2018 · 01 · 11 № 01/130  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН,  
БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,  
ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА Л.ЭЛДЭВ-ОЧИР  
ТАНАА

Зөвлөмж хүргүүлэх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 158 тоот зарлигийг хэрэгжүүлэх хүрээнд тариалангийн талбайн хөрсний үржил шимийг сайжруулах, элэгдэл эвдрэлээс хамгаалах зорилгоор Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас "Тариалангийн талбайн хөрсний тогтвортой ашиглалт, хамгаалалт" сэдэвт зөвлөгөөнийг 2017 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгуулсан.

Энэхүү зөвлөгөөнд манай улсын хөрсний чиглэлээр үйл ажиллагаа, судалгаа шинжилгээ явуулдаг их дээд сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд, төрийн болон төрийн бус байгууллагууд, газар тариалангийн салбарт ажиллаж байсан ахмад үеийнхэн зэрэг нийт 150 орчим төлөөлөл оролцож тариалангийн талбайн хөрсний үржил шим, органик бодисыг сайжруулах, хөрсний элэгдэл эвдрэл, бохирдол тэдгээрийг шийдвэрлэх арга замууд, хөрсний экологи эдийн засгийн үнэлгээ, хөрсний шинжилгээний арга зүй зэрэгт тулгарч буй асуудлуудыг хэлэлцэх, шийдвэрлэх арга замыг тодорхойлох чиглэлээр илтгэл тавьсан ба Дани улсын Копенхагены их сургууль, Байгаль орчны экологийн хими, физикийн сургуулийн захирал Профессор, Бяарнэ Штробел, хөрсний бохирдлын чиглэлээр илтгэл тавин оролцсон.

Зөвлөгөөнд оролцогсод дээрх илтгэл, хэлэлцүүлгийг үндэслэн цаашид Монгол Улсын Засгийн газар, хариуцсан яам төрийн байгууллага, аж ахуйн нэгжүүдийн түвшинд тариалангийн талбайн хөрсний үржил шимийг сайжруулах, элэгдэл эвдрэлийг бууруулах хүрээнд авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний талаарх өөрсдийн санал, хүсэлтийг тусгасан зөвлөмжийг боловсруулан хүргүүлж байна.

Хавсралт 3 хуудастай.



Б.БАТЗОРИГ

## “ТАРИАЛАНГИЙН ТАЛБАЙН ХӨРСНИЙ ТОГТВОРТОЙ АШИГЛАЛТ, ХАМГААЛАЛТ” ЗӨВЛӨГӨӨНӨӨС ГАРАХ ЗӨВЛӨМЖ

2017 он 11 дүгээр сар 29

Улаанбаатар хот

Зөвлөгөөний үеэр тавьсан илтгэлүүдийг үндэслэн тариалангийн хөрсийг хамгаалах, зохистой ашиглах зорилгоор дараах зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

### Улсын их хурлын түвшинд

- Монгол улсын хэмжээнд мөрдөх Хөрс хамгааллын тухай бие даасан хууль гаргах (энэ хуулинд хөрсний элэгдэл, эвдрэл түүнээс хамгаалах, хөрсний бохирдол түүнээс урьдчилан сэргийлэх, хөрсний үржил шимийг нөхөн сэргээх, түүнийг сайжруулахын тулд хөрсний экологи – эдийн засгийн үнэлгээ тогтоож, хэрэглэх, дотоодын эрдэс болон органик бордооны үйлдвэрүүдийг бодлогоор дэмжих, эдгээрийг шинжлэх ухааны үндэстэй оношлох лабораториудын үйл ажиллагааг зохицуулах зэрэг асуудлуудыг тусгах)
- Одоо мөрдөгдөж буй хөрс хамгаалал болон цөлжилтөөс сэргийлэх тухай хууль нь 2012 онд батлагдсан бөгөөд хөрс хамгаалал болон цөлжилт гэсэн 2 том ухагдахууныг нэг хуулиар зохицуулагдахаар тусгасан нь хүртээмж муутай хэмээн эрдэмтэн судлаачид үзэж байна. Газрын нэгдмэл сангийн 2016 оны тайланд дурьдсанаар Монгол орны нийт нутаг дэвсгэрийн 73,5 % нь хөдөө аж ахуйн зориулаттай газар бөгөөд нийт бэлчээрийн 73 хувь нь ямар нэгэн байдлаар доройтолд орсон бол тариалангийн газрын 60,1 хувь нь хүчтэй элэгдэлд өртсөн байна.

### Засгийн газрын түвшинд

- Монгол улсын Ерөнхийлөгчийн 2016 онд гаргасан “Хөрс, бэлчээр хамгаалах тухай” 158 тоот зарлиг, Тариалангийн тухай хууль, Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогод тариалангийн хөрсний чиглэлээр тусгасан заалтуудын хэрэгжилтийг ханган ажиллах,
- Ерөнхийлөгчийн зарлигийн хүрээнд тариалангийн талбайн хөрсний үржил шимийг сайжруулах, элэгдэл эвдрэлийг бууруулах чиглэлээр хөтөлбөр боловсруулан батлуулах ажлыг зохион байгуулж хөтөлбөрийн хүрээнд дор дурьдсан арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх. Үүнд:
  - Дундаас дээш элэгдэл, эвдрэл доройтолд орсон хөдөө аж ахуйн зориулттай газрын хөрсийг нөхөн сэргээх /ойн зурvas байгуулах, хашаажуулах, зурvasлан тариалах, ногоон бордуурт уринш гэх мэт/
  - Хөрс элдэншүүлэлтийг цомхотгох, хөрсний үржил шимийг тэтгэх сэлгүүлэн тариалалтыг дэмжих, нийт талбайд эрдэс болон шим бордоог хэрэглэх замаар хөрсний үржил шимийг сайжруулах

- Эх орны дотоодын органик болон эрдэс бордооны үйлдвэрүүдийг жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх арга хэмжээнд болон гадаад, дотоодын урт хугацааны хөнгөлөлттэй хөрөнгө оруулалтад бодлогоор хамруулан хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлэх
- Газар тариалан эрхлэдэг аж ахуйн нэгжүүдийг хөрсний үржил шимийг хамгаалж нэмэгдүүлсэн, таримлын сэлгээг шинэчлэн хөрсний үржил шимийг сайжруулсан, техникийн шинэчлэл хийсэн байдлыг нэн тэргүүнд харгалзан үзэж шалгаруулах, урамшуулах /улаан буудайн ургацад олгодог өнөөгийн урамшууллын тогтолцоог хөрс хамгаалах сайжруулах чиглэлд чиглүүлэх/, эдгээр арга хэмжээнүүдийг амжилттай хэрэгжүүлсэн аж ахуйн нэгж иргэдэд зээл санхүү, техник, бордоо, ургамал хамгааллын бодисоор хангахад хөнгөлөлт үзүүлэх
- Хөрсний экологи – эдийн засгийн үнэлгээг тариалангийн талбай бүрт хийж тариалангийн газрын татварыг тогтоох, хөрсний үржил шимийг сайжруулсан тохиолдолд урамшуулал өгөх, атаршсан газрыг иргэд аж ахуйн нэгжид олгох зэрэгт ашиглах
- Хөрсний нэр томьёо, задлан шинжилгээ, үнэлгээний арга зүй, стандартуудыг боловсруулж батлуулж мөрдүүлэх, их дээд сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдийн хөрс-агрохимич боловсон хүчиний чадавхийг нэмэгдүүлэх, хөрсний задлан шинжилгээний агрохимиин лабораториудын хүчин чадлыг сайжруулах
- Монгол улсад хэрэгжиж буй хөрстэй холбоотой хууль, бодлого, технологийн хэрэгжилтэнд хяналт тавьж, заавар, зөвлөмж өгч ажиллах
- Аймаг орон нутгийн газар тариалан хариуцагч мэргэжилтнүүд болон газар тариалан эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн агрономчдод зориулсан агро-инж-мех мэргэшлийн түр сургалтыг зохион байгуулах, ялангуяа ОХУ, Казахстанд хэрэгжүүлж буй технологи, туршлага судлах ажлыг зохион байгуулах
- Ногоон бордуурт уринш + буудай + буудай ээлжлэн тариалах сэлгээг нэвтрүүлэхэд шаардагдах хөмрүүлэгч анжис гэх мэт техник тоног төхөөрөмж болон буурцагт ургамлын үрийг худалдан авахад төрөөс нэг удаа санхүүгийн дэмжлэг, туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулах
- ЗГ-ын 149 тогтоолоор батлагдсан жил бүрийн Хөрс хамгаалах үндэсний өдрөөр хийсэн ажлаа тайлагнан, хэлэлцэж улсын хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлэх.

#### **Аж ахуйн нэгжийн түвшинд**

- Дундаас дээш элэгдэл, эвдрэл, доройтолд орсон хөрстэй талбайг нөхөн сэргээхэд төр захиргаа, эрдэм шинжилгээ, мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллаж, талбайн хөрсийг сайжруулах, хөрсний элэгдэл, эвдрэлээс хамгаалах арга хэмжээ тогтмол авч хэрэгжүүлэх

- Хөрс элдэншүүлэлтийг цомхотгох, талбайд хөрсний үржил шим тэтгэх таримлыг сэлгүүлэн тариалах, нийт талбайд эрдэс болон шим бордоог /тариалж буй талбайн 30 хүртэл хувьд шим бордоо хэрэглэх/ хэрэглэх замаар хөрсний үржил шимийг сайжруулах
- Хөрсний үржил шимийг хамгаалах зорилгоор элэгдэл эвдрэлийн зэргээс хамаараад сул элэгдсэн талбайд нэг наст буурцагтан /вандуй/, дунд элэгдсэнд хоёр наст буурцагтан /хошоон/, хүчтэй элэгдсэн талбайд олон наст буурцагтан /царгас/ -г тус тус сэлгээнд оруулах
- Хөрсний үржил шимиин доройтол, тэжээлийн бодисын ядуурал, бохирдлоос урьдчилан сэргийлэх, тариалангийн талбайн хөрсний бохирдлыг 5 жил тутамд лабораторийн задлан шинжилгээгээр тогтоож, үр дүнг төр захиргааны байгууллагад мэдээлэх.

Энэхүү зөвлөмжийг үндэслэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар Тариалангийн хөрсийг тогтвортой хамгаалах, ашиглах чиглэлээр үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж жил бүрийн Хөрс хамгаалах үндэсний өдрөөр үр дүнг тайлагнаж байх.

#### ЗӨВЛӨГӨӨНД ОРОЛЦОГСОД